

ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Энэхүү үнэлгээний аргачлалын дагуу “Тавантолгой” ХК (цашид ТТХК гэх)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дунг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хянаж баталсан болно.

Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал
4. Аудит, хяналтын тогтолцоо
5. Эрсдэлийн удирдлага
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал
7. Оролцогч талуудын эрх ашиг
8. Компанийн соёл
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Үнэлгээний аргачлал

Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан бол 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан бол 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулав.

Үнэлгээний нэгдсэн дунд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Үнэлгээний нэгдсэн дүн

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн ондоо	Хяналтын ондоо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6		100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100%
5	Эрсдэлийн удирдлага	8	4		66,6%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		100%
8	Компанийн соёл	6	5		83,3%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9		90%
10	Нэгдсэн дүн	72	66		93,3%

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар
сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан
"Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 1

Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт					
<p>"Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ.</p> <p>Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекст дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.</p>					
НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
<p>Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.</p>					
	Xэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь	
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	"Тавантолгой" ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг баталж тус журмаар зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулан ажиллаж байна.	2	100
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	"Тавантолгой" ХК Өмнөговь аймгийн орон нутгийн өмчийн оролцоотой дурмийн сангийн 51 хувийг Өмнөговь аймгийн иргэд зээмшдэг хуулийн этгээд юм. Аймгийн ИТХ-ын 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 16/05 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн оролцоотой "Тавантолгой" ХК-ийн орон нутгийн өмчийг төлөөлөх ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах журам, гүйцэтгэх удирдлагын сонгон шалгаруулалтад тавигдах ерөнхий шаардлагыг баталж тус журмын хүрээнд ТУЗ-д орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулж томилон ажиллуулж байна.	2	100

3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд холбогдох мэдээллийг оруулан тайлагнадаг. Хөрөнгийн биржийн цахим хуудас болон өөрийн компанийн цахим хуудсанд гишүүд нэг бүрээр мэдээллийг байршуулдаг.	2	100
4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрмийг хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар шинэчлэн баталсан ба дүрэмд төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтцийн талаар нарийвчлан тусгасан өгсөн мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тус асуудлуудыг бүрэн тусган зохицуулж өгсөн	2	100
5	1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жил бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилогдсон ТУЗ-ийн гишүүдийг гишүүнээр анх томилогдоход чиглүүлэх сургалт, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтыг зохион байгуулж байна. 2025 оны 4 сард шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдийг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо болон компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс ТУЗ-ийн гишүүдийг гишүүнээр анх томилогдоход чиглүүлэх сургалт, ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалт авсан.	2	100

6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицстой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицстой явуулах, ТУЗ болон компани гүйцэтгэх удирдлага түүний нэгж хэлтэстэй харилцах эрх зүйн орчин, төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээх эрх үүргийг нарийвчлан зохицуулж егсөн.	2	100
Дүн				12	100

**ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД,
ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ**

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.

7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн туравны нэг нь хараат бус гишүүн байхаар тусгаж хууль тогтоомж, дүрмийн хэрэгжилтийг ханганд ажиллаж байна.	2	100
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцно.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус хараат бус гишүүн байхаар тусгасан ба Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцож байна.	2	100

9	2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцож.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус хараат бус гишүүн байхаар тусгасан ба цалин урамшууллын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцож байна.	2	100
10	2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус хараат бус гишүүн байхаар тусгасан ба нэр дэвшүүлэх хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцож байна.	2	100
11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрмийн 8 дугаар зүйлд шаардлагатай үед түр хороо байгуулж болно гэж тусгасан байдаг. Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороодууд нь Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар үйл ажиллагааг явуулж байна.	2	100
Дүн				10	100
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.					

12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлгагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас www.tavantolgoi.mn Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас www.mse.mn хаягаар хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагч, олон нийтэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, нээлттэй тайлгнадаг.	2	100
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас www.tavantolgoi.mn , Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас www.mse.mn хаягаар хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагч, олон нийтэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, нээлттэй тайлгнадаг.	2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлгнэл нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй байршуулдаг бөгөөд тухайн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт, аюулгүй байдал, байгаль орчин, нийгмийн хариуцлага, цаашдын зорилт, тогтвортой хөгжлийн талаар мэдээллүүдийг бэлтгэн оруулдаг.	2	100
Дүн			6	100	
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.					

	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хороны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортай харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТУЗ-ийн Аудитын хороо хөндлөнгийн аудитыг сонгох боломж нээлттэй байдаг. Компанийн хувьд орон нутгийн өмч давамгайлсан хувьцаат компани учраас Төрийн аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудитыг сонгон шалгаруулалтаар ажиллуулдаг. Тухайн дүгнэлтийг гүйцэтгэх удирдлагаар дамжуулж ТУЗ-д танилцуулдаг.	2	100
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хөндлөнгийн аудитын гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд компанийн удирдлагууд танилцуулдаг. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд дүгнэлтийг байршуулан ажилладаг.	2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, дотоод журам, бүтэц бүрэлдэхүүнд тусгасны дагуу ТУЗ-ийн дэргэд дотоод аудитын албыг, гүйцэтгэх захирлын дэргэд дотоод хяналтын хэлтсийг ажиллуулдаг бөгөөд цаашид олон нийтэд мэдээллэж ажиллаж байна	2	100
Дүн				6	100
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.					

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн “Дотоод хяналт шалгалтын журам”-д заасны дагуу хяналт шалгалт хийж гүйцэтгэх удирдлагад тайлагнадаг. ТУЗ-ийн дэргэд дотоод аудитын алба, гүйцэтгэх захирлын дэргэд дотоод хяналтын хэлтсийг компанийн бүтцэд тусгаж эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавин ажиллаж байна.	2	100
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд Дэд хороо байгуулж болох талаар тусгагдсан ба хорооны бүтцийн хувьд 2/3 нь хараат бус гишүүн байхаар зохицуулагдсан. Тиймээс цаашид ТУЗ-ийн дэргэд эрсдэлийн удирдлагын хороотой байхыг зорино.	1	50
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд БОНБНҮ-г хийлгэж, 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэн ажиллаж байгаа. Нийгмийн хариуцлагыг өндөрт хэрэгжүүлж ажиллаж байгаа. Аюулгүй байдал эрсдэлийн удирдлагын менежментийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.	2	100
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Энэ талаар компанийн дотоод хяналтын журмаар зохицуулдаг ба хэрэгжилтэд Гүйцэтгэх удирдлага хяналт тавьж ажилладаг.	1	50

	Дүн	4	66,6
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.			
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал, давтамж зэргийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталдаг.
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хөдөлмөрийн дотоод журмын шинэчилсэн найруулга, цалин, урамшууллын журамд ажлын гүйцэтгэл үнэлэх KPI шалгуур, ажил үүргийн бүрдэл хэсэг зэргийг тусгасан байдаг.
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын хооронд байгуулсан гэрээнд цалин, урамшууллын хэмжээг тусгайлан заасан байдаг. Тухайн жил бүр зорилтот түвшинг ТУЗ-өөр баталгаажуулан гэрээ, тайланд заасан байдаг ба урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг гэрээнд заасан байдаг
	Дүн	6	100
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.			
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамtran ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамtran ажиллах соёлыг байгууллагын төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм болон Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээнд тусгайлан заасан байдаг. Компанид мөрдлөг болгон ашигладаг “Төрийн байгууллага, хуулийн этгээдтэй харилцах журам”-ыг баримтлан ажилладаг ба Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамtran ажиллах соёлыг төлөвшүүлэн ажиллаж байна.

26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн ажиллагааны тайланд стратегийн ач холбогдол бүхий талуудтай хамтран ажилласан талаар мэдээллийг тусган танилцуулдаг.	2	100
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудсыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн цахим орчинд мэдээллийг нээлттэй байнга байрлуулж байна.	2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дотоод журамд санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх асуудлыг тусгасан бөгөөд Үйлдвэрчний эвлэлтэй хамтарсан “Хамтын гэрээг” байгуулан ажиллаж байгаа.	2	100

НАЙМЛУГААР ЗАРЧИМ КОМПАНИЙН СОЁЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, яаралын манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.

29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны журамд тодорхой хэлбэрээр буюу “Ес зүйн дүрэм”-д суулгасан бөгөөд ёс зүйн дүрмийг шинэчлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа ба төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.	1 50
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны журамд тодорхой хэлбэрээр буюу “Ес зүйн дүрэм”-д заасан байдаг.	2 100

31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны журамд тодорхой хэлбэрээр буюу “Ёс зүйн дүрэм”-д зааснаар зохицуулдаг.	2	100
----	--	--------------------	--	---	-----

Дүн

5 83,3

ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.

32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж өөрийн цахим хуудас болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийт, хөрөнгө оруулагч наарт мэдээллэн ажиллаж байна.	2	100
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланда тусган мэдээлэл хүргүүлэн ажилладаг. Цаашид хөтөлбөрийг боловсруулан баталж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг зорино.	1	50
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь орон нутгийн өмч давамгайлсан баӨмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бусад хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, санал гаргах, мэдээлэл авах боломжоор бүрэн хангаж ажилладаг ба жил бүр үйл ажиллагааны тайлан мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэлдэг.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Нээлттэй хувьцаат компани учир энэ асуудлаар хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд ямар нэг асуудал гардаггүй.	2	100

36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зерчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавьж дүгнэлт гаргадаг ба мэдээллийг компанийн албан ёсны цахим хуудаст бусад мэдээлэл гэсэн хэсэгт байршдаг.	2	100
	Дүн		9	90	
	Нэгдсэн дүн		66	93,3	

Санамж:

Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

Тухайлбал, "МХБ" ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.

Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.БӨХБАТ

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:
ТУЗ-ИЙН ДАРГА



2025 оны Долодугаар сарын 9-ны өдөр